

**АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБООНЫ
2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

НЭГ . ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1 Товч танилцуулга
- 1.2 Бүтэц, зохион байгуулалт, орон тоо, хөрөнгийн байдал

ХОЁР. ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

- 2.1 Даатгалын сан бүрдүүлэх нөхөн төлбөр олгох, буцааж төлүүлэх талаар
- 2.2 Мэдээллийн сан үүсгэж, холбооны гишүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог хангах мэдээлэл солилцох талаар
- 2.3 Даатгалын тохиолдлыг үнэн зөв тодорхойлж үйлчилгээ үзүүлэх Шуурхай албаны талаар
- 2.4 Албан журмын даатгалыг хэрэгжүүлэх, даатгалын тухай хуулийн мэдээлэл, мэдлэгийг олон нийтэд олгох, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, сурталчилгааны талаар

ГУРАВ. ДОТООД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

- 3.1 Санхүүгийн тайлан үр дүнгийн талаар
- 3.2 Орон нутгийн салбарын үйл ажиллагаа, үр дүн
- 3.3 Дотоод хяналт, салбар, нэгжийн ажил дүгнэсэн тухай

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ


НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ:

1.1 Товч танилцуулга

Улсын их хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Жолоочийн даатгалын тухай хуулийг баталж, Даатгалын тухай хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, Санхүүгийн зохицуулах хороо 2011 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 301 дугаар тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлийн анхны бүрэлдэхүүнийг баталснаар, мөн оны 11 сарын 07-ны өдөр Албан журмын даатгагчдын холбоо (ТББ) үүсэн байгуулагджээ. Тус холбоо нь Даатгалын санг бүрдүүлж, нөхөн төлбөр олгох, даатгалын сангийн шуурхай албыг зохион байгуулах, жолоочийн даатгалын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, албан журмын даатгалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй даатгагчдын үйл ажиллагаа, уялдаа холбоог ханган зохион байгуулах, зам тээврийн ослыг бууруулах, жолоочийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа хийх үүрэгтэй, гишүүддээ үйлчилдэг ашгийн төлөө бус хуулийн этгээд юм.

Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрч, Удирдах зөвлөл баталсан дүрмийн дагуу АЖДХолбооны үйл ажиллагаа явагдаж байна. Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлд Албан журмын даатгагчдын холбооны эрх, үүргийг тодорхойлсон нь онцлог гэж хэлж болно.

АЖДХолбооны Удирдах зөвлөлийн 2016 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан зохион байгуулалтын бүтцийг танилцуулбал:



2016 онд, Удирдах зөвлөл нийт 8 удаагийн хуралдаан хийж, 34 тогтоол гаргаж, “Жолоочийн даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн авлагыг ангилах, эрсдлийн сан байгуулах, зарцуулах тухай журам” болон Албан журмын даатгалын шуурхай албаны үйл ажиллагаанд мөрдөх заавар, зөвлөмжийн хуудас, шуурхай албаны ажилтнуудад тавигдах шалгуур, шаардлагыг журамлах тухай, Албан журмын даатгагчдын холбооны 2017 оны төсвийн тухай, 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай тогтоолуудыг тус тус хэлэлцэж баталлаа. Мөн, Холбооны нэрэмжит шагналыг бий болгож шагнал олгох журмыг батлуулсан байна.

Даатгалын тухай хуулийн 12¹,6-д заасан эх үүсвэрээр холбооны хөрөнгийг, Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1-д заасан эх үүсвэрээр жолоочийн даатгалын санг бүрдүүлж, зарцуулалтын тайланг гаргаж байна. Даатгалын сан, холбооны 2015, 2016 оны хөрөнгийн байдлыг (хүснэгт №1-ээр) харуулбал:

Хүснэгт №1 /мянган төгрөгөөр/			
№	Хөрөнгийн нэр	2015 оны жилийн эцсийн байдлаар	2016 оны жилийн эцсийн байдлаар
1	Мөнгөн хөрөнгө	195 188,6	70134,6
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /хадгаламж/	5 199 992,7	6954868,6
3	Авлага	1 355 770,5	2 209 143,7
4	Эргэлтийн хөрөнгө	6 772 654,5	9 255 388,6
5	Үндсэн хөрөнгө	642 839,4	528502,6
6	Биет бус хөрөнгө	62 886,5	191503,2

Даатгалын тухай хуулийн 12¹.1-д албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгагч нь Холбооны гишүүн байна гэж заасан байдаг. Холбооны хөрөнгө гишүүдийн элсэлт, тухайн жилийн татвараас үндсэндээ бүрдэж байгаа бөгөөд Удирдах зөвлөлөөс баталсан зориулалтын дагуу зарцуулж байна. 2016 оны жилийн эцсийн байдлаар, Гүйцэтгэх захирал нийт 212 тушаал гаргаснаас 66 нь нөхөн төлбөртэй холбоотой асуудлаар, 29 нь ажилд томилох, 45 нь хөдөлмөрийн гэрээ цуцалсан, 24 нь /давхардсан тоогоор/ цалин хөлс, урамшуулал тэтгэмж олгох тухай шийдвэр байгаа бөгөөд үндсэн үйл ажиллагаатай холбоотой 138 шийдвэр гарчээ. Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 02/138 тушаалаар Холбооны хөдөлмөрийн дотоод журмыг нийт ажилтнуудаар хэлэлцэн шинэчилж мөрдүүлээ.

Холбооны нийт бичиг хэргийн эргэлт 1174, үүнээс албан байгууллага иргэдээс 326 албан бичиг, өргөдөл гомдол 172-ийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлэж албан байгууллага, иргэдэд нийт 848 албан бичиг явуулсан байна.

Монгол улсад албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан даатгалын 15 компани, даатгалын 3241 төлөөлөгч ажиллаж байна. Холбоо нь Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар, даатгалын мэргэжлийн оролцогчидтой хамтран ажиллаж дараах үр дүнд хүрсэн байна.

ХОЁР. ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГТ ХАМААРАХ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

2.1 ЗАМ, ТЭЭВРИЙН ОСЛЫН УЛМААС УЧИРСАН ХОХИРЛЫГ БАРАГДУУЛАХ, ХОХИРОГЧИД НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХ ЗАРЧИМД ТУЛГУУРЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЯВУУЛЖ БҮЙ ДААТГАЛЫН САНГИЙН ТАЛААР:

Монгол улсын Их хурлаас 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Жолоочийн даатгалын тухай хууль”- ийн тавдугаар бүлгийн 22.1-д Жолоочийн даатгалын санг үндсэн 6 төрлийн эх үүсвэрээр бүрдүүлэхээр заасан. Холбоо нь хуулийн дагуу даатгалын сангийн орлого төвлөрүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Хуульд заасан эх үүсвэрийг бүрдүүлэхэд аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, болон гишүүн даатгалын компаниудтай хамтран ажилласнаар даатгалын санд 2016 оны жилийн эцсийн байдлаар 3,078,595 мян. төгрөг төвлөрүүлж жилийн тодотгосон төлөвлөгөө 71,16 хувийн биелэлттэй байна.

2.1.1 Даатгалын сангийн бүрдүүлэлтийн талаар

Даатгалын сангийн 2016 онд төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг (хүснэгт №2) харуулбал:

Хүснэгт 2 /мянган төгрөг/

№	Орлогын төрөл	2015 оны гүйцэтгэл	2016 оны төсөв	2016 оны тодотгосон төсөв	2016 оны гүйцэтгэл	Биелэлтийн хувь
1	Авто тээврийн болон өрөө явагч хэрэгслийн албан татварын 10 хувь /АТБӨЯХАТ/	1 696 185,0	3 284 470,50	3185577,9	2 033 381,1	63,83
2	Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байгаа даатгагчдаас төвлөрүүлэх хөрөнгө	447 311,0	450 000,0	390 133,0	390 133,0	100
3	Жолоочийн даатгалын хууль тогтоомжийн зөрчилд ногдуулсан торгуулийн орлого	3 936,0	5 000,0	5 000,0	480,0	9,6
4	Мэдээллийн санг төлбөртэй ашиглуулсны орлого	32 697,1	30 000,0	30 000,0	34 989,2	116,6
5	Хүүгийн орлого	631 008,3	717 024,0	615 024,0	518 692,4	84,3
6	Нөхөн төлбөрийн буцаан төлөлт	94 902,4	100 000,0	100 000,0	100 919,3	100,9
	Нийт дүн	2 906 039,8	4 586 497,5	4 325 734,9	3 078 595,0	71,16

2.1.2 Даатгалгүй, даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд замын хөдөлгөөнд оролцохдоо бусдад учруулсан хохирлыг арилгахаар Даатгалын сангаас олгосон нөхөн төлбөрийн талаар:

Жолоочийн даатгалын сан 2013 оноос эхэлж ажилласан бөгөөд 2016 онд, даатгалын тохиолдлын хохирогчийн нөхөн төлбөр олгохыг хүссэн нийт 72 өргөдөл хүлээн авч Жолоочийн даатгалын тухай хууль түүнийг дагаж гарсан журам, заавар, тушаалын дагуу судалгаа хийж, баримтын бүрдлийг хангуулан ажиллав.


Жолоочийн даатгалын тухай хуулийн 18.1 дэх заалтын дагуу даатгалын сангаас хохирогчийн өргөдлийг үндэслэн нөхөн төлбөр олгож, мөн хуулийн 20.2 дахь заалтын дагуу нөхөн төлбөрийг буруутай этгээдээс буцаан нэхэмжлэх гэрээг байгуулахдаа Жолоочийн даатгалын тухай хууль, Албан журмын даатгагчдын холбооны гүйцэтгэх захирлын 2015 оны 01 сарын 30-ны өдрийн 02/06 тоот тушаалын хавсралт 1-6 –г удирдлага болгон ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд 64 хохирогчид 157,129,540.0 төгрөгийн нөхөн төлбөрийг даатгалын сангаас олгосон бөгөөд нөхөн төлбөр авахыг хүссэн боловч бичиг баримт нь хуулийн шаардлагад нийцээгүй 2 хохирогчид 2,070,000 төгрөгийн нөхөн төлбөр олгохоос

татгалзаж, 6 хохирогчийн 19,900,900 төгрөгийн хохирол бүхий өргөдөл, бичиг баримт бүрдүүлэлтийн шатанд хянагдаж байна. Нийт 19 хохирогчид хохирол үнэлгээний хөлсөнд буцааж нэхэмжлэхгүй нөхцөлтэйгөөр 1.463.000 төгрөг даатгалын сангаас олгожээ.

Жолоочийн даатгалын сангаас тайлангийн хугацаанд хохирогчид олгосон нийт нөхөн төлбөрийн 72,2 % буюу 94,262,584 төгрөгийн нөхөн төлбөрийг ЖДТХ-ийн 18.1.1-дэх заалт, 26,3 % буюу 57,886,956 төгрөгийн нөхөн төлбөрийг ЖДТХ-ийн 18.1.2-дахь заалт, 2,8 % буюу 5,000,000 төгрөгийн нөхөн төлбөрийг ЖДТХ-ийн 18.1.5-дахь заалтуудыг тус тус үндэслэн даатгалын тохиолдлын хохирогчид олгосон болно.

Нөхөн төлбөр нэхэмжилсэн 72 өргөдлийг ЖДТХуулийн 18 дугаар зүйлийн “ЖДСангаас нөхөн төлбөр олгох” заалтын дагуу задалж харуулбал:



18.1.1 буюу даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан 52 өргөдөл нь нийт нөхөн төлбөр нэхэмжилсэн өргөдлийн 72,2 хувийг, 18.1.2 буюу даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргаж 19 өргөдлөөр нөхөн төлбөр нэхэмжилсэн нь 26,3 %-ийг тус тус эзэлж байна. 18.1.3 буюу бусдын амь нас эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус, 18.1.4 буюу даатгагч дампуурсан заалтуудыг дурдаж нөхөн төлбөр нэхэмжлээгүй байна. 18.1.5 буюу бусад үндэслэлээр 1 өргөдлийг шийдвэрлэжээ.

2016 онд, нөхөн төлбөрийн буцаан төлөлтөөр 100,919,300 төгрөгийн орлого жолоочийн даатгалын санд төвлөрсөн байна. /Хүснэгт 3/

№	Жолоочийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгох үндэслэл	Нөхөн төлбөр хүүссэн өргөдлийн тоо	Нэхэмжилсэн дүн	Өргөдлийн шийдвэрлэлт						Тухайн онд шийдвэрлэгдээгүй өргөдөл		Буцаан төлөлт
				Даатгалын сангаас олгосон		Даатгалын хохирол үнэлгээний төлбөрт олгосон		Даатгалын сангаас олгохоос татгалзсан				
				тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	тоо	мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн	
1	Даатгалгүй этгээд даатгалын тохиолдол гаргасан /18.1.1/	52	116,233,484	44	94,262,584	12	822,000	2	2,070,000	6	19,900,900	73,175,500
2	Даатгалын гэрээний хугацаа нь дууссан этгээд даатгалын тохиолдол гаргасан /18.1.2/	19	57,866,956	19	57,866,956	7	641,000		-	-	-	26,063,800
3	Бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан этгээд тодорхой бус /18.1.3/	0	-	-	-	-	-					
4	Даатгагч дампуурсан /18.1.4/	-	-	-	-	-	-		-		-	
5	Хууль тогтоомжид заасан бусад үндэслэл /18.1.5/	1	5,000,000	1	5,000,000	-	-		-	-	-	1,680,000
Дүн		72	179,100,440	64	157,129,540	19*	1,463,000	2	2,070,000	6	19,900,900	100,919,300

Тайлбар: Нийт 19 даатгалын тохиолдлын хохирол үнэлгээний хөлсөнд 1.463.000 төгрөгийг олгосон.

2013 оны дүн	50	92,896,882	19	40,544,132	-	-	26	41,149,520	5	11,203,230	9,725,640
2014 оны дүн	91	201,631,161	64	150,724,960	46	3,223,400	14	23,145,566	13	27,760,635	60,651,872
2015 оны дүн	65	152,107,397	49	113,984,504	27	1,744,500	10	25,070,893	6	13,052,000	94,902,364
2016 оны дүн	72	179,100,440	64	157,129,540	19	1,463,000	2	2,070,000	6	19,900,900	100,919,300
Нийт дүн	278	625,735,880	196	462,383,136	92	6,430,900	52	91,435,979	30	71,916,765	266,199,176

Тайлбар 2013-2016 онд нийтдээ 72 даатгалын тохиолдлын буруутай этгээд нь 77,937,804 төгрөгийн бусдад учруулсан хохирлоо өөрөө хариуцан тухайн үед нь бэлнээр төлж барагдуулсан дүнг оруулаагүй байна.

2013 оноос хойш, Жолоочийн даатгалын сангаас нийт 196 даатгалын тохиолдлын хохирогчид 462,3 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосоноос 266,1 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж оны эцэст 113 хүнээс 196,3 сая төгрөгийн авлагатай байна.

2.2 АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЧИГ ҮҮРЭГТЭЙ ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН ТАЛААР:

Мэдээллийн сан нь Даатгалын тухай хуулийн 12¹.3.1-д заасан чиг үүрэг болон Албан журмын даатгагчдын холбооны гишүүн, даатгагч, даатгуулагч нарт өөртэй нь холбоотой мэдээллээр, жолоочийн даатгалтай холбоотой хэрэг маргааныг хянан шийдвэрлэж буй төрийн байгууллага, албан тушаалтанд үнэ төлбөргүй мэдээллээр хангах үүрэг гүйцэтгэж байна.

Холбооны гишүүдийнхээ ажлын уялдаа холбоог хангахад мэдээллийн сангийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн МИИС систем чухал үүрэг гүйцэтгэж байна.

Даатгагч, зуучлагчид жолоочийн хариуцлагын даатгалын гэрээ хийхдээ манай холбооны санаачилгаар 2014 онд боловсруулж хэрэгжүүлсэн МИИС онлайн системийг ашигладаг. Энэ системийг өмчлөх эрхийг АЖДХолбооны Удирдах зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Албан журмын даатгагчдын холбооны өмчлөлд бүрэн шилжүүлсэн нь Холбооны цаашдын ирээдүй төдийгүй хариуцлагын даатгалын хөгжилд их ач холбогдолтой боллоо.

Мэдээллийн онлайн системээр итгэлцүүрийн өөрчлөлтийг тооцоолж хураамжийн хэмжээг бодож үйлчилдэг учир гэрээ хийхэд буруу зөрүү хийх асуудал байхгүй болсон гэж үзэж байна.

Мэдээллийн сангийн үйл ажиллагаанд МИИС систем нэвтрүүлж, шаардагдах хөгжүүлэлт хийснээр даатгалын гэрээ хийх үйл ажиллагаа хэвийн явагдаж даатгалын гэрээний мэдээ, мэдээлэл шуурхай нэгтгэгдэж мэдээллийн сангийн чанар сайжрав.

Гэвч, даатгагчид даатгалын нөхөн төлбөр олголт, даатгалын тохиолдолтой холбоотой мэдээллээ тэр даруйд нь бүртгүүлэхгүй нөхөж хийх, зарим мэдээллийг орхигдуулах, цаг хугацааны хувьд хоцроох, хойрго хандах дутагдал үргэлжилсээр байна.

Хэдийгээр энэ байдлыг Санхүүгийн зохицуулах хорооны баталсан журмаар зохицуулж сар, улирлын тайлан мэдээ тулгах ажлыг даатгалын компани бүрээр хийж шахаж шаардан ажиллаж байгаа боловч даатгалын компаниуд тухайн журмыг хэрэгжүүлэх ажилд хойрго хандах, хэрэгжүүлэх арга механизм буруу, тухайлбал, зөвшөөрөл олгох ажлыг өөрчилж дахин авч үзэх зэрэг шийдвэрлэх асуудал олон байна.

Даатгалын тохиолдлын дуудлага, бүртгэхээс эхлээд нөхөн төлбөр олгох хүртэлх шат дамжлага бүрийг нэгдсэн байдлаар хяналт тавих боломж бүрдүүлэх, хохирол үнэлэх ажил, засварын газар, замын цагдаа, шуурхай алба, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага зэргийг хамруулан бүртгэлжүүлэх, УИХ-ын 2011 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулах шаардлага бий болжээ.

Даатгалын хохирол үнэлгээ хийх компанийг сонгох, сонгосон хохирол үнэлэгч нь үнэлгээ хийж хохирогчид хүргэх зэрэг үйл ажиллагааг онлайнаар хийх программыг манай холбоо боловсруулсан боловч нэгдсэн байдлаар даатгалын компаниуд хэрэгжүүлэхгүй байна.

Өнөөдрийн байдлаар, мэдээллийн санд нэг сая гаруй хувь хүний мэдээлэл байгаа нь мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, сүлжээний тоног төхөөрөмжүүдийн аюулгүй байдлыг хангах, гадны халдлага, хууль бус хандалтаас хамгаалах чадамжийг нэмэгдүүлэх асуудал нэн тэргүүнд тавигдаж байна. Энэ асуудлыг шийдвэрлэхээр хоёр дахь жилдээ төсөвт зардал нь тусгагдсан боловч хэрэгжүүлж эхлээгүй байсныг 2016 оны эцсээр тендерийн даалгавар боловсруулж сонгон шалгаруулалт явуулж гүйцэтгэгчийг сонгож ажилд орууллаа.

Даатгагчдаас жолоочийн даатгалын гэрээг интернет орчинд хийх боломж нээж өгөх хүсэлт тавьсаныг судалж холбогдох бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэв.

Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компани 2016 онд МИИС систем ашиглаж нийт 552045 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 26,618,949,849 төгрөгийн даатгалын хураамжийн орлого олсон байна. Энэ нь даатгалын салбарын энэ оны нийт хураамжийн орлогын 30 орчим хувийг эзэлж байна.

Даатгалын мэргэжлийн оролцогч Улаанбаатар хот болон Дархан уул, Орхон аймгийн зуучлагч нарт даатгалын гэрээ байгуулахад мөрдөгдөх журамд оруулсан өөрчлөлт, түүнийг

хэрхэн хэрэгжүүлэх мэдээллийн сангаас цаашид баримтлах чиглэлийн талаар 2 удаагийн сургалт зохион байгуулав.

Жолоочийн даатгалын гэрээг ангиллын хувьд авч үзвэл хувь хүний 432376, хуулийн этгээдийн 100506, мэргэшсэн болон C,D ангиллын жолоочийн 13856, дамжин өнгөрөхийн 5307 гэрээ байгуулагдсан байна. Даатгалын компани тус бүрийн байгуулсан жолоочийн даатгалын гэрээний тоо, хураамжийн дүнгийн хэмжээг Хүснэгт 4 - оос харна уу.

Хүснэгт 4. /Даатгалын компани болон гэрээний ангиллаар/

№	Нэрс	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн, C,D		Дамжин өнгөрөх		Нийт гэрээний тоо	Нийт хураамжийн дүн
		Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн		
1	Соёмбо даатгал	14084	565,134,029	4735	434,048,588	741	21,905,473	6	1,032,985	19566	1,022,121,075
2	Миг даатгал	68703	2,761,502,081	13331	1,022,098,118	1348	39,961,460	57	3,881,725	83439	3,827,443,384
3	Мөнх даатгал	584	22,128,938	713	64,436,059	254	7,412,870	3916	319,023,095	5467	413,000,962
4	Монгол даатгал	85134	3,305,157,671	18026	1,593,882,512	2904	86,815,155	619	24,316,458	106683	5,010,171,796
5	Практикал даатгал	38437	1,457,916,616	8822	790,601,826	1418	46,652,495	218	9,324,143	48895	2,304,495,080
6	Гэр даатгал	3076	128,827,882	1394	104,735,807	132	3,982,899	2	25,000	4604	237,571,588
7	Улаанбаатар хотын даатгал	46	2,447,675	91	7,192,845	0	0	0	0	137	9,640,520
8	Номин даатгал	30871	1,232,730,704	5609	500,200,213	772	23,422,888	11	758,498	37263	1,757,112,303
9	Тэнгэр даатгал	23891	962,401,641	8627	834,489,298	1312	38,814,011	27	1,071,486	33857	1,836,776,436
10	Бодь даатгал	60006	2,389,743,560	9671	812,579,940	881	24,587,628	211	11,130,637	70769	3,238,041,765
11	Ганзам даатгал	91	3,990,391	236	18,425,341	79	2,297,130	0	0	406	24,712,862
12	Монре даатгал	29594	1,172,121,835	6260	481,496,406	387	11,291,767	11	432,960	36252	1,665,342,968
13	Ард даатгал	25257	965,028,790	6660	572,963,384	755	22,039,206	15	973,691	32687	1,561,005,071
14	Мандал даатгал	40413	1,809,053,113	12739	931,039,109	622	18,454,910	201	11,710,726	53975	2,770,257,858
15	Хаан даатгал	12189	472,771,023	3592	384,447,137	2251	83,350,466	13	687,555	18045	941,256,181
Нийт дүн		432376	17,250,955,949	100506	8,552,636,583	13856	430,988,358	5307	384,368,959	552045	26,618,949,849

ОН	Хувь хүн		Хуулийн этгээд		Мэргэшсэн, CD		Дамжин өнгөрөх		Нийт гэрээний тоо	Нийт хураамжийн дүн
	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн	Тоо	Хураамжийн дүн		
2014 оны дүн	392345	12,517,686,000	94249	6,364,385,000	12830	429,944,000	432	340,780,000	499856	19,345,095,596.0
2015 оны дүн	406572	14,361,184,249	98506	7,324,645,983	15267	490,770,600	3911	241,921,071	524256	22,418,521,903.0
2016 оны дүн	432376	17,250,955,949	100506	8,552,636,583	13856	430,988,358	5307	384,368,959	552045	26,618,949,849.0

График 2. Жолоочийн даатгалын гэрээний тоо /Даатгалын компаниар/





График 3. Жолоочийн даатгалын гэрээний хураамжийн харьцаа /Гэрээний ангиллаар/
2015 он 2016 он



Дээрх графикаас 2016 онд хувь хүний даатгалын гэрээний хураамжийн орлого 3 тэрбум гаруй төгрөгөөр өссөн үзүүлэлтийг харж болно. Өнгөрсөн онуудтай харьцуулахад хувь хүн, хуулийн этгээд, дамжин өнгөрөхийн гэрээний тоо тогтмол өссөн байна. Харин Мэргэшсэн C,D ангиллын даатгалын гэрээний тоо 2015 онтой харьцуулахад 50 сая гаруй төгрөгөөр багасчээ.

Жолоочийн даатгалын гэрээг газар нутгийн байршлаар гэрээний тоо, хураамжийн хэмжээг Хүснэгт 5-с харна уу.

Хүснэгт 5. Жолоочийн даатгалын гэрээ /Газар нутгийн байршлаар/

№	Аймаг, нийслэл	Даатгалын гэрээний тоо		Хураамжийн дүн	
		/2015 он/	/2016 он/	2015 он	2016 он
1	Архангай	7,786	8,974	244,617,932	314,567,149
2	Баян-Өлгий	7,394	8,135	224,742,596	276,080,312
3	Баянхонгор	8,918	10,095	273,919,589	350,668,400
4	Булган	7,277	8,271	224,118,987	289,470,671
5	Говь-Алтай	6,329	7,012	195,234,089	242,042,416
6	Говьсүмбэр	2,332	2,432	88,997,693	99,138,911
7	Дархан-Уул	12,589	13,674	491,052,465	586,330,206
8	Дорноговь	8,925	10,097	320,563,738	394,939,827
9	Дорнод	8,451	8,832	264,709,668	318,097,310
10	Дундговь	6,514	7,096	189,791,707	234,723,577
11	Завхан	6,824	8,327	220,802,315	298,321,753
12	Орхон	16,253	17,949	628,154,001	763,793,293
13	Сэлэнгэ	12,571	14,421	434,683,927	589,446,500
14	Сүхбаатар	8,222	8,291	245,580,242	285,979,006
15	Төв	10,903	11,303	352,710,701	442,996,316
16	Увс	7,701	8,085	238,645,511	276,775,320
17	Улаанбаатар	326,056	332,611	15,456,108,010	17,863,528,952
18	Ховд	7,017	7,634	237,911,249	285,485,698
19	Хэнтий	8,923	9,456	278,519,965	333,334,216
20	Хөвсгөл	12,242	12,826	383,271,108	448,453,184
21	Өвөрхангай	12,793	13,236	392,398,269	465,163,906
22	Өмнөговь	14,360	15,446	792,256,480	953,009,982
	Нийт	520,380	544,203*	22,178,790,242	26,112,346,905*

*дамжин өнгөрсөн тээврийн хэрэгслийн даатгалын гэрээний тоо, үнийн дүн /Хүснэгт 2-ын 9,10 дугаар багана дахь/-гээр зөрж байгаа болно.


2.2.1 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР

2016 онд, Албан журмын даатгагчдын холбооны гишүүн 15 даатгалын компанийн даатгуулагчдаас нийт 30,483 хүн жолоочийн даатгалын тохиолдол гаргаж 14,374,654,324 төгрөгийн нөхөн төлбөр авсан байна. Даатгалын тохиолдлын улмаас үүссэн хохирлыг эрсдлийн ангилал тус бүрээр авч үзвэл, тээврийн хэрэгсэлд учруулсан хохирол 29,762 даатгалын тохиолдолд 13,573,934,653 төгрөгийн нөхөн төлбөр, эд хөрөнгөд хохирол учруулсан 346 даатгалын тохиолдолд 285,720,923 төгрөгийн нөхөн төлбөр, амь насанд хохирол учруулсан 39 даатгалын тохиолдолд 145,253,932 төгрөгийн нөхөн төлбөр, эрүүл мэндэд хохирол учруулсан 336 даатгалын тохиолдолд 369,744,816 төгрөгийн нөхөн төлбөр тус тус олгосон байна. Даатгалын компани тус бүрийн 2016 онд хохирогчдод олгосон нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээг 2015 оныхтой харьцуулж (Хүснэгт 6-аас) харна уу.

Хүснэгт 6. Нөхөн төлбөр /Даатгалын компани, эрсдлийн ангиллаар/

№	Даатгагч	Тээврийн хэрэгсэл			Бусад хөрөнгө		Амь нас		Эрүүл мэнд		Нийт Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн
		Он	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн	Д/Т тоо	Олгогдсон нөхөн төлбөрийн дүн		
1	Соёмбо даатгал	2015	698	364,562,267	13	10,326,481	3	19,023,000	8	12,122,133	722	406,033,881
		2016	789	384,884,612	11	6,233,460	3	13,066,750	8	15,295,010	811	419,479,832
2	Миг даатгал	2015	5298	1,355,560,838	141	100,405,800	10	28,225,786	87	62,071,788	5536	2,546,264,212
		2016	4562	2,096,081,375	71	47,413,544	9	31,319,220	85	74,596,447	4727	2,249,410,586
3	Мөнх даатгал	2015	23	18,218,720	1	571,662	-	-	-	-	24	18,790,382
		2016	27	14,146,010	0	0	0	0	0	0	27	14,146,010
4	Монгол даатгал	2015	5019	1,250,219,864	74	74,005,613	15	48,802,084	112	106,640,597	5220	2,479,668,158
		2016	4950	2,318,118,724	75	75,497,010	9	32,958,912	67	93,011,924	5101	2,519,586,570
5	Практикал даатгал	2015	1598	750,207,140	31	31,927,279	7	26,019,535	24	24,090,968	1660	832,244,922
		2016	1851	1,004,044,792	30	30,549,792	2	9,760,000	43	44,326,084	1926	1,088,680,668
6	Гэр даатгал	2015	93	45,514,710	0	0	0	0	2	635,600	95	46,150,310
		2016	208	82,154,813	2	1,170,790	1	4,000,000	2	1,351,944	213	88,677,547
7	УБ хотын даатгал	2015	7	2,616,200	0	0	0	0	0	0	7	2,616,200
		2016	7	3,685,000	0	0	0	0	0	0	7	3,685,000
8	Номин даатгал	2015	1943	829,034,168	36	33,267,528	5	9,739,000	17	10,480,919	2001	882,521,615
		2016	1741	722,738,948	29	25,432,985	2	10,238,670	36	51,452,033	1808	809,862,636
9	Тэнгэр даатгал	2015	2181	1,015,075,679	28	28,374,214	3	15,000,000	25	26,423,081	2237	1,084,872,974
		2016	1961	970,819,996	59	44,435,211	2	11,500,000	22	33,136,647	2044	1,059,891,854
10	Бодь даатгал	2015	5211	1,035,631,578	53	39,738,289	15	50,469,232	87	59,990,496	5366	2,185,829,595
		2016	4369	1,823,163,352	4	2,914,881	2	8,081,500	8	4,731,298	4383	1,838,891,031
11	Ганзам даатгал	2015	53	27,030,895	0	0	0	0	0	0	53	27,030,895
		2016	14	6,706,100	0	0	0	0	1	120,000	15	6,826,100
12	Монре даатгал	2015	2268	1,051,301,976	33	38,355,365	0	0	0	0	2301	1,089,657,341
		2016	2036	826,294,154	0	0	0	0	0	0	2036	826,294,154
13	Ард даатгал	2015	2593	1,557,609,481	27	35,166,123	7	25,480,400	6	9,042,900	2633	1,627,298,904
		2016	1916	906,316,673	26	22,412,174	9	24,328,880	46	41,152,102	1997	994,209,829
14	Мандал даатгал	2015	2423	849,796,117	104	46,307,861	0	0	0	0	2527	896,103,978
		2016	4249	1,722,329,764	32	21,076,829	0	0	0	0	4281	1,743,406,593
15	Хаан даатгал	2015	460	218,433,123	8	9,452,525	2	4,623,739	7	8,323,031	477	240,832,418
		2016	1022	542,992,456	4	1,132,247	0	0	17	10,351,671	1043	554,476,374
16	АЖДХ	2015	48	109,295,234	1	3,292,140	0	0	1	1,397,130	50	113,984,504
		2016	60	149,457,884	3	7,452,000	0	0	1	219,656	64	157,129,540
Нийт дүн		2015	29,916	13,480,107,990	550	451,190,880	67	227,382,776	376	321,218,643	30,909	14,479,900,289
		2016	29762	13,573,934,653	346	285,720,923	39	145,253,932	336	369,744,816	30483	14,374,654,324

График 4. Нөхөн төлбөрийн дүн, даатгалын компаниар /мянган төгрөг/



Хүснэгт 7. Нөхөн төлбөр /Газар нутгийн байршлаар/

№	Аймаг, нийслэл	Даатгалын тохиолдлын тоо		Нөхөн төлбөрийн дүн	
		2015 он	2016 он	2015 он	2016 он
1	Завхан	32	60	18,270,629	35,869,152
2	Баянхонгор	38	68	27,251,095	23,360,929
3	Ховд	40	39	21,263,544	26,473,570
4	Архангай	43	58	31,223,092	35,873,275
5	Говь-Алтай	49	55	22,880,047	41,469,359
6	Дундговь	54	83	56,692,137	61,304,849
7	Булган	54	67	48,258,053	85,668,955
8	Увс	56	72	34,476,874	36,596,760
9	Баян-Өлгий	57	77	21,700,396	43,516,993
10	Сүхбаатар	58	65	39,073,397	42,801,264
11	Говьсүмбэр	61	33	28,901,074	30,909,475
12	Хэнтий	81	88	64,301,716	65,362,796
13	Өвөрхангай	88	128	64,904,488	98,304,095
14	Хөвсгөл	90	89	45,766,153	42,355,989
15	Өмнөговь	102	130	56,111,988	119,368,951
16	Дорноговь	115	138	84,506,269	86,691,190
17	Дорнод	147	136	91,225,041	94,944,310
18	Төв	200	219	257,792,447	250,849,776
19	Сэлэнгэ	203	244	183,760,433	184,363,984
20	Дархан-Уул	388	340	230,821,131	191,731,106
21	Орхон	473	634	230,299,097	339,682,236
22	Улаанбаатар	28,480	27,596	12,820,421,188	12,280,025,770
23	АЖДХолбоо	49	64	113,983,504	157,129,540
Нийт:		30,958	30,483	14,593,883,793	14,374,654,324

Хүснэгт 8. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ /төгрөг/

№	Нэрс	Нөхөн төлбөрийн тоо		Нөхөн төлбөрийн нийт дүн	
		2015 он	тоо 2016	2015 он	2016 он
1	200,000 хүртэлх	13804	11,036	1,767,271,341	1,459,538,372
2	200,000-500,000 хүртэлх	12118	12,167	3,741,703,337	4,038,804,235
3	500,000-800,000 хүртэлх	3371	3,396	2,102,699,811	2,122,437,058
4	800,000-1,000,000 хүртэлх	1055	1,105	936,996,524	986,804,756
5	1,000,000-1,500,000 хүртэлх	1283	1,265	1,559,595,459	1,536,611,944
6	1,500,000-2,000,000 хүртэлх	580	559	997,066,364	960,951,540
7	2,000,000-3,000,000 хүртэлх	439	450	1,061,446,506	1,079,172,933
8	3,000,000-4,000,000 хүртэлх	222	233	760,470,201	793,380,598
9	4,000,000-5,000,000 хүртэлх	121	125	531,123,901	554,420,852
10	5,000,000-8,000,000 хүртэлх	172	136	887,767,052	709,088,850
11	8,000,000-10,000,000 хүртэлх	11	9	103,939,793	81,876,625
12	10,000,000	2	2	29,820,000	51,566,562
	Нийт дүн	33,178	30,483	14,479,900,289	14,374,654,325

График 5. Нөхөн төлбөрийн тоо, нөхөн төлбөрийн хэмжээ.



2.2.2. ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ХУРААМЖИЙН ОРЛОГО, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ХАРЬЦАА

Жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж буй 15 даатгалын компани 2016 оны жолоочийн даатгалын хураамжийн орлогоос 26,618,949,849 төгрөгийн хураамжийн орлого олж, 53,41%- хувийг буюу 14,217,524,784 төгрөг нөхөн төлбөрт олгосон байна.

Хүснэгт 9. Жолоочийн даатгалын хураамжийн орлого, нөхөн төлбөрийн харьцаа

№	Нэрс	Нийт хураамжийн дүн /төг/		Олгогдсон нөхөн төлбөрийн нийт дүн /төг/		Хураамжийн орлогод н/т-ийн эзлэх хувь	
		2015 он	2016 он	2015 он	2016 он	2015 он	2016 он
1	Соёмбо даатгал	784,856,238	1,022,121,075	406,033,881	419,479,832	51,7%	41.04%
2	Миг даатгал	3,743,975,039	3,827,443,384	2,546,264,212	2,249,410,586	68,0%	58.77%
3	Мөнх даатгал	199,699,999	413,000,962	18,790,382	14,146,010	9,4%	3.43%
4	Монгол даатгал	3,927,745,568	5,010,171,796	2,479,668,158	2,519,586,570	63,1%	50.29%
5	Практикал даатгал	1,497,667,484	2,304,495,080	832,244,922	1,088,680,668	55,6%	47.24%
6	Гэр даатгал	61,094,695	237,571,588	46,150,310	88,677,547	75,5%	37.33%
7	Улаанбаатар хотын даатгал	12,914,751	9,640,520	2,616,200	3,685,000	20,3%	38.22%
8	Номин даатгал	1,228,075,315	1,757,112,303	882,521,615	809,862,636	71,9%	46.09%
9	Тэнгэр даатгал	1,698,187,272	1,836,776,436	1,084,872,974	1,059,891,854	63,9%	57.70%
10	Бодь даатгал	3,386,064,276	3,238,041,765	2,185,829,595	1,838,891,031	64,6%	56.79%
11	Ганзам даатгал	18,892,510	24,712,862	27,030,895	6,826,100	143,1%	27.62%
12	Монре даатгал	1,602,705,030	1,665,342,968	1,089,657,341	826,294,154	68,0%	49.62%
13	Ард даатгал	2,063,290,528	1,561,005,071	1,627,298,904	994,209,829	78,9%	63.69%
14	Мандал даатгал	1,664,772,345	2,770,257,858	896,103,978	1,743,406,593	53,8%	62.93%
15	Хаан даатгал	528,580,853	941,256,181	240,832,418	554,476,374	45,6%	58.91%
	Нийт:	22,418,521,903	26,618,949,849	14,365,915,785	14,217,524,784	64,1%	53,41%

2.2.3 ЖОЛООЧИЙН ДААТГАЛД ЗУУЧЛАГЧДЫН ҮҮРЭГ ӨСЧ БАЙНА.

Жолоочийн даатгалд зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан 20 зуучлалын компани 2016 онд 202,614 жолоочийн даатгалын гэрээ байгуулж, 9,341,260,170 төгрөгийн даатгалын хураамжийн орлого оруулжээ. Үүнээс 7 банк даатгалын үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр банкнууд 69,108 гэрээ байгуулж, 3,079,892,855 төгрөгийн даатгалын хураамжийн орлого оруулсан байна.

Хүснэгт 10. Жолоочийн даатгалын гэрээ /Зууч компаниар/

Д/Д	Даатгалын зууч компани	Жолоочийн даатгалын гэрээний тоо		Жолоочийн даатгалын гэрээний хураамж		Нийт гэрээний тоонд эзлэх хувь	
		2015 он	2016 он	2015 он	2016 он	2015 он	2016 он
1	Сүрэг хараацай	39,306	51,136	1,676,111,155	2,432,145,628	7,5%	9.26%
2	Смарт брокерс	11,252	18,735	455,309,218	857,572,111	2,1%	3.39%
3	Хаан банк	3,902	3,731	120,207,201	136,055,972	0,7%	0.68%
4	Лоялти солюшн	14,767	1,219	614,989,445	48,282,479	2,8%	0.22%

5	Эрсдлийн шийдэл	36,843	11,382	1,444,600,920	529,523,439	7,0%	2.06%
6	Ачит-ундарга	273	155	14,976,248	9,065,854	0,1%	0.03%
7	Төрийн банк	12,770	15,650	426,240,956	575,004,390	2,4%	2.83%
8	Капитал банк	52	78	2,293,771	5,201,279	0,0%	0.01%
9	Монгол бичээч	2,509	5,880	97,760,285	282,953,458	0,5%	1.07%
10	Ари гбанк	52	31	3,250,223	2,026,078	0,0%	0.01%
11	Дэвжих дэлгэрэх	1,611	8,524	72,283,413	422,690,340	0,3%	1.54%
12	ҮХО-ын банк	36,180	45,879	1,605,320,890	2,168,004,697	6,9%	8.31%
13	ХАС банк	99	448	5,015,601	21,980,640	0,0%	0.08%
14	Мастер шийдэл	2,442	138	105,744,035	6,795,838	0,5%	0.02%
15	Ххб	1,275	2,536	58,544,172	140,552,617	0,2%	0.46%
16	Lbbrokerage ХХК	2,001	9,120	97,286,334	425,396,041	0,4%	1.65%
17	Соёмбо ай би	11	3	724,332	160,380	0,0%	0.00%
18	Си эн эн икс	164	4,283	7,558,307	186,276,556	0,0%	0.78%
19	Цагаан гэрэлт	1,211	4,206	51,183,689	171,769,415	0,2%	0.76%
20	Тод капитал	-	12,764	-	600,573,134	-	2.31%
21	Эй Эс Ай Би	-	108	-	6,165,019	-	0.02%
22	SIBS	-	1,720	-	79,036,732	-	0.31%
23	Нэйшнл Эженси	-	2,968	-	142,335,472	-	0.54%
24	MIB	-	31	-	1,863,097	-	0.01%
Нийт		166,720	200,725	6,859,400,195	9,251,430,666	31,8%	34,75%

Нийт жолоочийн даатгалын гэрээнд зуучлагчдын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2,95 хувиар өсчээ.

2.2.4 ЖОЛООЧИЙН ДААТГАЛД ХАМРАГДСАН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН СУДАЛГАА


Тээврийн хэрэгслийн ангиллаар нь 2016 оны даатгалын гэрээний тоог харвал В ангиллын тээврийн хэрэгсэл 481,624 гэрээ байгуулж, 21,320,990,623 төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлсэн нь нийт гэрээний 87,22 хувийг, хураамжийн орлогын 80 хувийг эзэлж байна.

Хүснэгт 11. Жолоочийн даатгалын гэрээ /Тээврийн хэрэгслийн ангилал/

№	Зүйл	Гэрээний тоо			Хураамжийн дүн		
		2014 он	2015 он	2016 он	2014 он	2015 он	2016 он
1	А	16,306	13,290	12,313	203,137,771	165,101,945	162,368,596
2	В	415,465	437,576	481,624	14,645,866,990	17,124,704,545	21,320,990,623
3	С	36,317	38,306	38,584	2,853,998,922	3,275,618,925	3,636,105,198
4	Д	15,071	15,134	14,889	1,099,301,920	1,198,021,870	1,315,067,029
5	М	3,599	4,223	4,189	91,605,193	107,519,930	119,571,828
6	Бусад		472	446	203,137,771	57,291,269	64,846,575
Нийт		486,758	509,001	552,045*	18,893,910,796	21,928,258,484	26,618,949,849*

*мэргэшсэн жолоочийн даатгалын гэрээний тоо, үнийн дүн /Хүснэгт 2-н 7,8-р багана дахь/-гээр зөрж байгаа болно.

Тээврийн хэрэгслийн бүртгэл, оношлогоо, татвар болон жолоочийн даатгалд хамрагдалтын үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар график 6-аар харуулбал: График 6



2.2.5 МЭДЭЭЛЛИЙН САНГААС ОЛГОСОН ЛАВЛАГАА

Мэдээллийн сангийн лавлах 70121177 дугаарын утсанд ирсэн иргэд, даатгалын компани, зуучлагчид, хамтран ажилладаг төрийн болон хувийн компаниудын санал гомдол, хүсэлт гаргасан 2579 гаруй дуудлагад хариу өгч иргэд, даатгагч, зуучлагчдад мэдээлэл солилцох боломж олгожээ.

Хүснэгт 12. Мэдээллийн сангийн утсанд ирсэн дуудлага

№	Дуудлагын утга	Лавлагааны тоо	
		2015* он	2016 он
1	Нөхөн төлбөрийн лавлагаа	1641	869
2	Даатгалын компаний ажилтны лавлагаа	84	3
3	Хууль тогтоомжийн лавлагаа	84	30
4	Даатгалын сангийн лавлагаа	128	42
5	Мэдээллийн сангийн лавлагаа	372	453
6	Даатгалын гэрээний лавлагаа	1057	904
7	Санал гомдол	44	41
8	АЖДХ ажилтны лавлагаа	27	80
9	Даатгалын компаний утасны дугаар, хаяг байршил	79	64
10	Бусад	93	93
НИЙТ		3609	2579

*Мэдээллийн сангийн дуудлага бүртгэл, лавлагааны систем 2015 онд ашиглалтад орсон тул өнгөрсөн 2013, 2014 онуудын дуудлагын дэлгэрэнгүй дүн мэдээ бүртгэгдээгүй болно.

Мэдээллийн сан даатгалын компани, даатгалын зуучлагч нарт жолоочийн хариуцлагын даатгалыг хэрхэн хийх, даатгагч нарт хураамжийн хэмжээг зөв тооцох, холбогдох хууль журмыг тайлбарлах талаар холбогдох сургалт нэгдсэн байдлаар болон тухайн компанид очиж тайлбарлаж сургалт хийх зэрэг ажлыг тогтмол хийж байна.

Мөн мэдээллийн сангийн лавлах утсанд ирж байгаа даатгалын мэдвэл зохих ёстой мэдээллийг давтан асууж байгаа даатгалын компаниудад дотоод сургалтыг сайжруулах, давтан сургалт хийх талаар сануулж ажиллалаа. Эдгээр ажлын үр дүнд даатгуулагч нарын хуулийн мэдлэг сайжирч даатгагч нарын үйл ажиллагаанд чанарын өөрчлөлт гарч манай Холбооны лавлах утсанд ирэх гомдол саналын тоо (3609-ээс 2579) 28,5 % иар буурсан байна.

2015 онд иргэдийн нөхөн төлбөрийн лавалгааны дуудлага ихэнх нь иргэд байсан. Өнгөрсөн 2016 онд нөхөн төлбөрийн лавалгааны дуудлага буурч байгаа нь иргэдийн итгэлцүүрийн журмын мэдлэг дээшилсэн, даатгалын гэрээнд нөхөн төлбөр авч байсан жолооч нэмэгдэх үед үндсэн хураамжинд хэрхэн нөлөөлдөг талаар ойлголт сайтай болсныг харуулж байна.

2.3 ДААТГАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХОХИРОГЧ, ИРГЭНЭЭС ДААТГАЛЫН ТОХИОЛДЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ ДААТГАЛЫН ТОХИОЛДЛЫГ ШУУРХАЙ ҮНЭН ЗӨВ ТОДОРХОЙЛОХ БОЛОМЖИЙГ ДААТГАГЧ, ДААТГУУЛАГЧ, ХОХИРОГЧИД БҮРДҮҮЛЭХ, ЧИГ ҮҮРЭГТЭЙ ШУУРХАЙ АЛБАНЫ ТАЛААР:

Шуурхай алба нь Даатгалын тухай хуулийн 12¹.3.2; Жолоочийн даатгалын тухай хуулийн 25.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж хохирогчдод туслалцаа үзүүлэхийн зэрэгцээ салбарын шуурхай албаны үйл ажиллагаанд хяналт тавьж зааварчилгаа өгөх, орон нутгийн замын цагдаагийн тасаг болон авто тээврийн газруудтай хамтран шалгалт хийж даатгалын зөрчилтэй жолооч нарыг илрүүлэх, зөрчлийг арилгуулах, иргэд, даатгуулагчдыг мэдээ мэдээллээр хангах ажлыг гүйцэтгэж байна.

Жолоочийн даатгалын тухай хууль хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор замын хөдөлгөөнд оролцож байгаа авто тээврийн хэрэгсэлд ЗЦА-тай хамтран хяналт шалгалтын ажил хийж даатгалд хамрагдаагүй, гэрээний хугацаа дууссан тээврийн хэрэгслийг илрүүлэх, даатгалд хамруулахад анхаарч ажиллалаа.

Тайлант хугацаанд, Жолоочийн даатгалын тухай хуулийн тодорхой заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн тээврийн газартай “Хамтран ажиллах санамж бичиг”, Автотээврийн үндэсний төв болон Замын цагдаагийн албатай /гурвалсан/ “**Хамтран ажиллах тухай санамж бичиг**”-ийг нэг жилийн хугацаатай байгуулж хэрэгжилтийг дүгнэв.

Мөн АвтоСОС ХХК-тай 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 1 жилийн хугацаатай “Хамтран ажиллах тухай санамж бичиг” байгуулсны дээр АЖДХ-ны Удирдах зөвлөлийн хурлаар даатгалын шуурхай албанд мөрдөж ажиллах зарим эрхийн актыг батлах болсонтой холбогдуулан өмнө нь боловсруулж бэлэн болгоод байсан шуурхай албаны стандартыг “**Албан журмын даатгалын шуурхай албаны үйл ажиллагаанд мөрдөх заавар**” болгон

өөрчилж, “**Шуурхай албаны ажилтнуудад тавигдах шалгуур, шаардлага**”, “**Жолоочийн даатгалын шуурхай албаны ажилтны сургалтын хөтөлбөр**”-ийн хамт боловсруулан Холбооны Удирдах зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлуулж, нийт даатгагчид болон Холбооны орон нутаг дахь салбаруудад хүргэж, хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

АЖДХ-ны Шуурхай албаны ажиллах журам Хорооны тогтоолоор батлагдаж, 2 удаа шинэчлэгдэх явцдаа шаардлагатай заалтууд нэмэгдсэн хэдий ч зарим хэрэгтэй заалтууд хаягдсан тул 5 жил шахам хугацааны ажлын туршлагад тулгуурлан мөн журмын шинчилсэн төсөл боловсруулж Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлээ.

Даатгалын шуурхай албанд тавигдах нийтлэг шаардлага, ач холбогдлыг тусгасан журам боловсруулах, түүнийг даатгагчдын холбооны болон түүний гишүүн даатгагч нарт жигд мөрдүүлэхэд цаашид анхаарал тавих шаардлага байгаа юм.

2016 онд, Ажлын албаны шуурхай албаны 70101177 дугаарын лавлах утсанд 2414 дуудлага, мэдээллийг, орон нутгийн салбаруудын дуудлагын утсанд 13599 дуудлага, мэдээллийг тус тус хүлээн авснаас жолоочийн хариуцлагын даатгалын 861 тохиолдлын (48 нь даатгалын сангийн, 813 нь даатгалын компаниудын) дуудлага хүлээн авч даатгагч, даатгуулагч нарт үйлчилсэн байна.

Нийт дуудлагын 5,37 хувь нь Жолоочийн хариуцлагын даатгалын тохиолдлын дуудлага байсан бөгөөд нийт даатгалын тохиолдол (28646) –ын 3 хувийг эзэлж байна.

2016 онд, Холбооны шуурхай албанд хүлээн авсан 16013 /орон нутгийн салбаруудын лавлах утсанд ирсэн лавлагаа мэдээллийн тоотой нэгдсэн дүн/ дуудлага, мэдээллийн үйлчилгээг /хүснэгт 15-аас/ дуудлагын төрлөөр задалж харуулвал:

Хүснэгт 13

№	Лавлах утсанд ирсэн дуудлагын төрөл	2016 он
1	Даатгалын тохиолдлын /Даатгалын сангийн дуудлагын хамт/ дуудлага	861
2	Хууль тогтоомжийн лавлагаа	1386
3	Мэдээллийн сангийн лавлагаа	1931
4	Даатгалын сан, нөхөн төлбөрийн лавлагаа	1167
5	Даатгалын компаний утас, байршлын лавлагаа	3316
6	Санал гомдол	377
7	Бусад мэдээлэл	6975
Дүн		16013


График 7



Үзүүлэлт	ДТ-ын дуудлага	Хууль тогтоомжийг лавлагаа	МС-ийн лавлагаа	ДС-ийн лавлагаа	Нөхөн төлбөрийн лавлагаа	ДК-ийн утас, байршил	бусад	нийт
2015	24	100	409	23	75	155	533	1323
2016	218	188	573	32	155	412	836	2414
Нийт дүн	242	288	982	55	230	567	1369	3737

Улаанбаатар хотод, шуурхай албаны лавлах утсаар хүлээн авсан дуудлагын тоог 2015, 2016 оноор харуулбал:

график 8



Дээрх графикаас харахад, иргэд даатгуулагч нар бидэнд хандаж асууж сонирхох лавлагааны бүтцэд төдийлөн өөрчлөлт ороогүй хэдий ч нийт лавлагаа дунджаар 50 орчим хувь өссөн үзүүлэлттэй байна.

Тайланд дурьдсан даатгалын тохиолдлын тоо бол зөвхөн тус Холбооны нийслэл болон орон нутгийн салбарын шуурхай албанд ирүүлсэн даатгалын тохиолдлын дуудлагаар очиж, үзлэг хийж баримтжуулсан тоо юм. АЖДХ нь 2016 онд нийслэлд жолоочийн даатгалын үйл ажиллагаа эрхэлдэг 3, орон нутагт 8 даатгалын компанитай гэрээ байгуулж тэдний даатгуулагчдын дуудлагаар даатгалын тохиолдлын газарт очиж үйлчилгээ үзүүлж ажилласан болно.

Өөрийн шуурхай албатай, түүгээрээ болон АвтоСОС-оор дамжуулан дуудлага хүлээн авч баримтжуулсан даатгалын тохиолдлын дуудлага Холбоонд нэгтгэгдэхгүй байгаа.

Иймээс цаашид Даатгалын тухай хуулийн 12¹.3.2, “Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны ажиллах журам”-ын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлэн өөрийн шуурхай албатай тус Холбооны гишүүн даатгалын компани бүр болон даатгагчдад шуурхай албаны үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж даатгалын тохиолдлын дуудлагын мэдээгээ Холбоонд тогтмол ирүүлдэг байхаар зохион байгуулалтын өөрчлөлт хийх шаардлагатай байна.

Энэ нь улсын хэмжээнд, тайлангийн хугацаанд хичнээн даатгалын тохиолдол гарсан, хэдэд нь даатгалын шуурхай үйлчилгээ үзүүлж баримтжуулсаныг үндэслэн нөхөн төлбөр олгосон тухай нэгдсэн мэдээлэл гаргах боломжтой болох юм.

Даатгалын сангийн ажилтнуудтай хамтарч 78 даатгалын тохиолдлын буруутай 77 этгээд, тэдгээрийн 71 батлан даагч нийт 149 хүний оршин суудаг хаягаар очиж уулзалт хийж нөхөн төлбөрийг хугацаанд нь төлүүлэх зорилготой хаягийн тодорхойлолтыг Даатгалын санд гаргаж өгөв.

Төв, орон нутгийн Шуурхай албаны автомашинуудын тусгай гэрэл дохио ашиглах зөвшөөрлийг 2016 оны 1 дүгээр сард сунгуулж хэвийн ажиллах нөхцлийг хангалаа.

Жолоочийн даатгалын тухай хууль зөрчиж даатгуулаагүй юмуу, даатгалын гэрээний хугацаа дууссан үедээ замын хөдөлгөөнд оролцож явсан жолоочийг мөн хуулийн 28.1.1-д заасны дагуу Замын цагдаагийн байцаагч торгож арга хэмжээ авч байсныг энэ оны 4 дүгээр сараас үндэслэлгүйгээр зогсоосноос жолооч дээрх зөрчил гаргаж замын хөдөлгөөнд оролцох тохиолдол олширч, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамрагдалт буурах магадлал бий болсон тул хуулийн дээрх заалтын хэрэгжилтийг яаралтай хангуулах шаардлагатай болоод байна.

2.4 ЖОЛООЧИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ, ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫГ БУУРУУЛАХ, АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ТАЛААР ОЛОН НИЙТЭД МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛ ОЛГОХОД ЧИГЛЭСЭН СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ НЬ ДААТГАЛД ХАМРАГДАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ХӨШҮҮРЭГ БОЛЖ БАЙНА.

Албан журмын даатгагчдын холбооноос гишүүн даатгагчид, даатгуулагчдын ажлын уялдаа холбоог хангах, тэдний ашиг сонирхол, эрх ашгийг хамгаалж хийж байгаа нэг ажил нь нийтийг хамарсан системтэй тасралтгүй зохион байгуулах сурталчилгааны ажил юм.

Албан журмын даатгагчдын холбооны ажлын алба, түүний орон нутаг дахь салбарууд сургалт, сурталчилгааны нэгдсэн зохион байгуулалттай ажиллаж байна.

Ажлын албанаас, МҮОНРадио, ТВ8, ТВ9, TV5, Эх орон, NTV телевизүүд болон өдөр тутмын сонин хэвлэл, олон хандалттай вебсайтуудаар дамжуулан телевизийн нэвтрүүлэг 36 удаа, радио нэвтрүүлгээр 21 удаагийн сурталчилгаа хийж гарын авлага, материал бэлтгэн орон нутагт хүргүүлж сургалт сурталчилгаанд өргөн ашиглаж байна. Мөн, ажлын албанаас бэлтгэсэн материалаар орон нутаг дахь салбарыг хангаж орон нутгийн мэдэллийн хэрэгслийг ашиглаж хамтран ажиллахын зэрэгцээ даатгагчдын төлөөлөгч, иргэд, аж ахуйн нэгжүүдэд сургалт тасралтгүй зохион байгуулж байна. Албан журмын даатгагчдын холбооноос 2016 онд Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, зам тээврийн ослыг бууруулах, даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэхтэй холбогдуулж даатгуулагч, даатгалын төлөөлөгч, зуучлагч нарыг мэдээллээр хангах, тэднийг чадавхижуулахад чиглэгдсэн сургалт, сурталчилгааны ажилд нийт 85,9 сая төгрөг зарцуулснаас 79,5 сая төгрөгийг сурталчилгаанд, 6,4 сая төгрөгийг сургалтанд зарцуулсан байна.

Албан журмын даатгагчдын холбоо Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх, олон нийтийн даатгалын мэдлэг, мэдээллийг сайжруулах тухай чиглэлийн сургалт, сурталчилгааны ажилд 2012 оноос хойш нийт 344,8 сая төгрөг зарцуулсан байна. Цаашдаа хариуцлагын даатгалын шинэ бүтээгдэхүүн бий болгоход сургалт, сурталчилгааны ажлыг хэрхэн зохион байгуулж үр дүнд хүргэж болохыг харуулж чадсан гэж үзэж байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах, зам тээврийн ослыг бууруулах, иргэд, олон нийт, даатгуулагч, даатгалын мэргэжлийн оролцогчдыг мэдээллээр хангаж, чадавхижуулахад чиглэгдсэн сургалт, сурталчилгааны дараах ажлуудыг тайлант хугацаанд зохион байгуулж ажиллалаа.

2016 онд сургалт, сурталчилгааны чиглэлээр хийсэн ажлыг 2015 оныхтой харьцуулж хүснэгт №15-аас харж болно.

А.Сургалт

Хүснэгт 15

№	Сургалтын			Хамрагдсан хүний тоо			
	Нэр	удаа		Улаанбаатар хотод		Орон нутагт	
		2015	2016	2015	2016	2015	2016
1	2	3	4	5	6	7	8
1. Даатгалын мэргэжлийн оролцогчдыг чадавхижуулах							
1.1	Даатгалын төлөөлөгчийн эрх олгох сургалт	22	13	120	270	735	447
1.2	Даатгалын шинэ ажилтныг мэргэшүүлэх сургалт-2016/ ДК-н салбарын ажилтнуудад 2015/	8	1	48	43	-	-
1.3	Даатгалын хохирол үнэлэгчдэд эрх олгох сургалт	1	2	15	62	-	-
1.4	Даатгалын хохирол үнэлэгчдийг мэргэшүүлэх сургалт	-	3	-	45	-	-
1.5	Даатгалын зуучлагч нарт МИИС систем ашиглаж гэрээ байгуулах эрх олгох сургалт	-	2	-	64	-	-
1.6	МХҮХ, БНСУ-ын Хохирол үнэлэгчдийн холбоотой хамтран “Даатгалын зохицуулалт, албан журмын даатгал, хохирлын үнэлгээ” сургалт	-	1	-	110	-	-
1.7	Даатгагчдын нэгдсэн шуурхай алба “Автосос”ХХК-ийн ажилтнуудыг чадавхижуулах	-	2	-	12	-	-
Дүн 1.1-1.7		31	24	183	606	735	447

1	2	3	4	5	6	7	8
2. Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах							
2.1	Төв, орон нутгийн Цагдаагийн байгууллагын замын цагдаагийн нэгжийн удирдах ажилтны зөвлөгөөнд оролцогч нарт сургалт	-	1	-	33	-	40
2.2	ХУД, БЗД, СБД, БГД, СХДүүргийн ЗЦХ-ийн алба хаагчдад	-	5	-	130	-	-
Дүн 2.1,2.2		-	6	-	163	-	40

1	2	3	4	5	6	7	8
---	---	---	---	---	---	---	---

3. Иргэд, олон нийт, даатгуулагчдад Жолоочийн даатгалын тухай хууль, түүний хэрэгжилтийг таниулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн сургалт							
3.1	Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлага болон инженер техникийн албан хаагчдад техникийн аюулгүй ажиллагааг ханган ажиллах чиглэлээр Нийслэлийн тээврийн газраас зохион байгуулсан сургалт			1	120		
3.2	“Хот хоорондын тээвэр эрхлэгчдийн холбоо ТББ”-аас нийтийн тээврийн жолооч нарт зориулсан сургалт			1	40		
3.3	Нийслэлийн тээврийн газрын урилгаар түүний удирдлагад			1	10		
3.4	Тахарын ерөнхий газрын автобаазын жолооч, инженер техникийн ажилтнуудад			1	25		
3.5	Багануур дүүрэг, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр зэрэг аймаг, хотын иргэд даатгуулагч нарт			78	1000		
3.6	Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай, Хөвсгөл, Булган, Орхон зэрэг 11 аймгийн иргэд даатгуулагч нарт,			111	-		4000
3.7	Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, албан байгууллага, жолооны курсуудад	239	172	-	-	9308	6881
ДҮН 3.1-3.7		239	172	193	1195	9308	10881
НИЙТ ДҮН 1.1-3.7		270	202	376	1964	10043	11368

2016 онд, Даатгалын мэргэжлийн оролцогчдыг чадавхижуулах 24 удаагийн сургалтаар төвийн 606, орон нутгийн 447 хүнд, Жолоочийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын ажилтнуудыг чадавхижуулах 6 удаагийн сургалтаар төвийн 163, орон нутгийн 40 хүнд, “Иргэд, олон нийт, даатгуулагчдад Жолоочийн даатгалын тухай хууль, түүний хэрэгжилтийг танилцуулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх” 172 удаагийн сургалтаар Улаанбаатар хотын 1195 иргэнд, орон нутгийн 10881 иргэнд тус тус мэдлэг мэдээлэл олголоо. 2016 онд нийт 202 удаагийн сургалтаар Улаанбаатар хотын 1964 иргэнд, орон нутгийн 11368 иргэнд сургалт явуулсан байна. 2015 онд, 270 удаагийн сургалтаар Улаанбаатар хотод 376 хүн, орон нутагт 10043 хүн хамрагдсан нь сургалтын тоо 2016 онд буурсан ч хамрагдах хүрээ өссөнийг харуулж байна.

В. Сурталчилгаа

1. Зам тээврийн ослыг бууруулах болон жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдлыг олон нийтэд хүргэхээр 18 төрлийн радио телевиз, ФМ- тэй хамтран ажиллах гэрээ байгуулан нийт 143 удаагийн давтамжтай мэдээ, мэдээлэл, зөвлөгөө, тодруулга, реклам, шторкийг нэвтрүүлээ.

Хүснэгт 16

№	Сурталчилгааны			Хамрагдалт	
	талбар		давтамж	Улаанбаатар хотод	Орон нутагт
1	TV8		25	Орон даяар	
2	TV9		27		
3	Эх орон ТВ		4		
4	NTV		2	Орон даяар	
5	HTV		1		
6	BloombergmongoliaTB		1		
7	MongolHD TB		2		
8	MNC TB		2		
9	SBN		3		
10	LCN		1		
11	Olloo TV		1		
12	Баян-Өлгий аймагт MNB-2 телевизээр		1		
13	Увс аймагт MBC Увс телевизээр		1		
14	Сүхбаатар аймагт BBH телевизээр		1	Орон даяар	
Дүн			72		
15	MYOHP	Гурван-Эрдэнэ студи	30		
		Тэнхлэг хөтөлбөр	3		
Дүн			33	УБ хотын иргэдэд	
16	FM	106	33		
		Авторадио 96,3	5		
Дүн			38		

Мөн, “Зам тээврийн ослыг бууруулахад төр олон нийтийн оролцоо” сэдэвт онлайн хэлэлцүүлгийг www.vip76.mn сайтаар, “Хүүхдийг зам тээврийн ослоос сэргийлье” хэвлэлийн бага хурлыг 43 хэвлэл мэдээллийн байгууллага, сонин, сайтын сэтгүүлчдэд, Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тухай болон зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх агуулгатай 3 төрлийн шторкийг Сошиал медиа болон ТВ8, TV9 телевизийн “Гарц” нэвтрүүлгээр орон даяар нэвтрүүлэхийн зэрэгцээ сошиал сурталчилгаа, Холбооны вебсайт, facebook хуудас болон vip76.mn, ikon.mn, shuud.mn, mnb.mn, assa.mn, bloombergtv.mn зэрэг сайтуудаар сурталчилгаа тогтмол хийж байна. Тайлант хугацаанд нийт 26500 ширхэг брошур, санамж хэвлүүлж 120 ширхэг сурталчилгааны самбар, плакатыг хийж нийслэл, орон нутгийн иргэдэд сурталчилгаа хийсэн байна.

Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн ослыг бууруулахад олон нийтийн оролцоог дэмжих, тэдний даатгалын тухай мэдлэгийг нэмэгдүүлэх, Монголбанк, Сангийн Яам, Боловсрол Соёл Шинжлэх Ухааны Яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос хамтран баталсан “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”- ийн хэрэгжилтийг хангах, иргэд өөрсдийн хэрэгцээнд тохирсон даатгалын бүтээгдэхүүн сонгож, өрхийн санхүүг зөв удирдах, оюутан залуус, бага насны хүүхдэд санхүүгийн сахилга баттай иргэн болж төлөвшихөд нь нөлөөлөх зорилгоор 10 дугаар сарын 20-наас 11 дүгээр сарын 20-ныг хүртэл хугацаанд “Жолоочийн даатгал-бидний амьдралд” эссэ бичлэгийн уралдааныг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэд, олон нийт, оюутан сурагчид гэсэн хоёр ангиллаар явууллаа. Уг уралдааныг Монголын хэвлэлийн хүрээлэнтэй хамтран зохион байгуулсан бөгөөд Замын цагдаагийн алба болон даатгалын мэргэжлийн холбоод дэмжиж оролцсон юм. Уралдаанд УБ хот болон аймаг, орон нутгаас нийт 161 эссэ бичлэг ирүүлсэн байна. Төв, Өмнөговь, Хэнтий, Увс аймгуудад тус уралдааныг зохион байгуулаагүй болохыг тэмдэглэж байна. Уралдаанд ирүүлсэн материалыг сэдвийн хүрээнд соён гэгээрүүлэх үүргийг хэрхэн гүйцэтгэсэн, шинжлэн судлаж нэгтгэн дүгнэсэн байдал, хэл найруулга, шалтгаан, үр дагаврын холбоо хамаарал, баримт ишлэлийг зохиогчийн өөрийн санаагаар хэрхэн дэмжсэн зэрэг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж, шалгаруулав. Уралдаанд шалгарсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнууд, оюутан сурагчдыг шагнаж шагналыг тус Холбооны Удирдах зөвлөлийн гишүүд гардуулав. Уралдаанд ирүүлсэн материалыг нийтэд нь авч үзвэл иргэдийн даатгалын тухай мэдлэг дээшилж даатгалд хамрагдах сонирхол өсч байгаа нь ажиглагдлаа.

Замын цагдаагийн албанаас сургуулийн насны хүүхдэд замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгох, замын хөдөлгөөнд аюулгүй оролцох дадал эзэмшүүлэх, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын дунд 10 дугаар сарын 25-ны өдрөөс 11 дүгээр сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд зохион явуулдаг “НОГООН ГЭРЭЛ - ЦАГААН ШУГАМ” тэмцээнд дэмжигч байгууллагаар сүүлийн 3 жил тасралтгүй оролцож байна.

Цаашдаа сургалт сурталчилгааны ажлыг даатгагчидтай хамтран ажиллах гэрээ байгуулж ажиллах нь илүү зохистой гэж үзэж байна.

ГУРАВ. АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ХОЛБООНЫ ДОТООД АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ЧУХАЛ НӨЛӨӨТЭЙ.

3.1 Санхүүгийн ажлын хүрээнд

Албан журмын даатгагчдын холбооны удирдах зөвлөлөөс 2016 оны төсөвт тодотгол хийж хөрөнгө оруулалтын зардлыг 90,0 сая төгрөгөөр бууруулж, орон тоог 19 хүнээр цөөрүүлэх шийдвэр гаргаж үйл ажиллагааны зардлын төсвийг 1,518,949 мянган төгрөгөөр,

хөрөнгө оруулалтын зардлын төсвийг 203,400 мянган төгрөгөөр баталж өгсөн. Энэ үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхэд сүүлийн 2 сарын ажил чиглэгдэж бүрэн биелүүлсэн болно.

Албан журмын даатгагчдын холбооны ажлын албаны 2016 оны төсвийн гүйцэтгэлийг 2015 оны гүйцэтгэлтэй харьцуулж харуулав.

/мян.төг/ Хүснэгт 17

л/д	Зардлын зүйл, төрөл	2015 оны гүйцэтгэл	2016 оны төсөв	2016 оны тодотгосон төсөв - 4 сар	2016 оны тодотгосон төсөв	2016 оны гүйцэтгэл	%-иар
1. Үндсэн үйл ажиллагааны зардлын төсөв							
1	АЖДХ-ны цалин хөлс	598 886,70	661 938,5	733,497.5	770,497.5	735 041,7	95,3
	Удирдах зөвлөлийн гишүүдийн нөхөн төлбөр	32 100,00		39,000.0	39 000,0	25 000,0	64,1
2	Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	61 890,40	72 813,2	80,684.7	80 684,7	75 614,7	94
3	Томилолтын зардал	16 937,30	45 000,0	45,000	45 000,0	14 616,9	32
4	Захиргаа аж ахуйн зардал Үүнээс:	22 971,90	30000,0	30,000	30 000,0	37 833,2	126,1
	Аж ахуйн зардал	2 630,70	2800,0	2,800	2 800,0	9 346,7	-
	Бичиг хэргийн зардал	7 000,00	7200,0	7,200	7 200,0	8 052,6	-
	Даатгал, оношлогоо, татвар, аудит	13 341,20	20 000,0	20,000	20 000,0	20 433,8	-
5	Конторын байр, гажийн түрээсийн зардал	210 086,80	247 120,8	276,486.8	276 486,8	233 054,5	84
6	Шатахуйн, сэлбэг, засварын зардал	34 844,70	43 200,0	51,000.0	51 000,0	35 393,9	69
7	Харилцаа холбооны зардал	27 526,20	31 200,0	31,200.0	31 200,0	29 076,1	93
8	Зар сурталчилгааны зардал	73 096,10	40 000,0	40,000.0	40 000,0	40 000,0	100
9	Сургалт, судалгаа, шинжилгээний зардал, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалтын санхүүжилт	10 177,60	120 000,0	120,000.0	120 000,0	45 998,6	38
10	Даатгалын тохиолдлын хохирол үнэлгээний зардал	1 744,50	3000,0	3,000.0	3 000,0	2 344,7	78
11	Орон нутгийн шуурхай албаны урсгал зардал	5 314,70	10 080,0	10,080.0	10 080,0	-	0
12	Бусад зардал	10 027,70	22 000,0	22,000.0	22 000,0	24 792,4	113
	Үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийн дүн	1 105 604,60	1 365 352,0	1,481,949.0	1 518 949,0	1 298 766,6	86
2. Хөрөнгө оруулалтын зардал							
13	Тавилга, эд хогшил, Компьютер, принтер, техник хэрэгсэл	14 990,50	15 000,0	25,000.0	25 000,0	25 206,5	101
14	Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах сервер, програм хангамж, хөгжүүлэлтийн зардал	12 343,40	150 000,0	150,000.0	150 000,0	138 350,0	92
15	Мэдээллийн сангийн программыг АТҮТөвтэй холбох зардал	-	25000,0	25,000	25 000,0	-	-
17	Санхүүгийн програм хангамж, аюулгүй байдлын зардал	1 956,00	3 400,0	3,400	3 400,0	-	-
18	Шуурхай албаны автомашин худалдан авах санхүүжилт	-	90 000,0	90,000	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардлын дүн	29 288,90	283 400,0	293,400	203 400,0	163 556,5	80
19	Хуульд заасан үндэслэлээр олгох нөхөн төлбөр	113 984,50	150 000,0	150,000	150 000,0	157 129,50	105
	Нийт зардлын дүн	1 248 878,0	1 798 752,0	1,925,349	1 872 349,0	1 619 452,6	86

Гүйцэтгэлээс үзэхэд төсөвлөсөн зардлуудын зарим зүйл дээр батлагдсан төсвөөс хэтэрсэн боловч нийт дүнгээрээ батлагдсан төсвийг хэтрүүлээгүй байна.

Батлагдсан хөрөнгө оруулалтын зардлаар “Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг сайжруулах” тендер зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж хөрөнгө оруулалтыг хийсэн байна.

3.2 Орон нутгийн салбарын үйл ажиллагаа, үр дүн

Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагааны үндсэн зорилт, Жолоочийн даатгалын тухай хууль, Удирдах зөвлөлийн шийдвэрээр батлагдсан Салбарын ажиллах журмын хэрэгжилт аймаг орон нутгуудад ямар түвшинд байгааг тодорхойлох, дүгнэлт гаргах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх зорилгоор салбаруудаас ирүүлсэн тайлангийн үр дүнг нэгтгэлээ.

Холбооны үйл ажиллагааны чиг үүрэг болон Жолоочийн даатгалын тухай хуулийн ач холбогдлыг сурталчлах, зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн сургалт, хяналт шалгалтыг орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагатай хамтран орон нутгийн даатгуулагч иргэдийн дунд тогтмол зохион байгуулсан байна.

Хуулийн ач холбогдлыг орон нутгийн иргэдэд сурталчилахад орон нутгийн Засаг даргын тамгын газар болон Замын цагдаагийн тасаг, Авто тээврийн газартай хамтран ажиллаж байгаа нь салбараас зохион байгуулсан үйл ажиллагаанд зохих дэмжлэг болж байгаа нь сайшаалтай байна. Тухайлбал, Булган, Төв, Завхан, Орхон, Өмнөговь, Увс, Говьсүмбэр, Сүхбаатар, Хөвсгөл болон ихэнх аймгууд нь хамтын ажиллагааны гэрээ, удирдамж зэргийг боловсруулан батлуулж ажиллажээ.

Салбарууд тухайн орон нутагт гишүүн даатгалын компаний салбаруудтай хамтран ажиллах, тэдний үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтад оруулах, жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, цаг үеийн болон тулгамдаж буй асуудлаар ярилцах, хамтарсан уулзалтыг тогтмол хийж ажилласан нь үр дүнгээ өгсөн юм. Ховд аймаг дахь салбар даатгалын компаний салбаруудын нийт 40 менежер, захирлуудтай уулзалт хийж санал солилцож сургалт хийсэн нь даатгалд хамрагдалтыг эрс сайжруулж чадсан жишээг олон аймаг дээр дурьдаж болно.

Жолоочийн даатгалын тухай хуулийн 22.1.4 дэх заалтын дагуу 21 аймаг АТБӨЯХАТ-ын 10 хувийг батлагдсан хуваарийн дагуу даатгалын санд төвлөрүүлэх ажилд нэлээд анхаарч ажилласан. 2016 онд 21 аймгаас нийт 787,987,100 төгрөг төвлөрөхөөс 773,381,100 төгрөг хуваарийн дагуу төвлөрсөн байна. Даатгалын санг бүрдүүлэхэд тус Холбооны орон нутаг дахь бүх салбарууд хангалттай ажилласан гэж үзэж байна. Ялангуяа Булган, Дундговь, Төв, Хөвсгөл, Хэнтий аймаг дахь салбарууд даатгалын санд 2016 онд төвлөрүүлэх хөрөнгийг 100 хувь төвлөрүүлсэн байна.

Тайлангаас харахад салбарууд аймгийнхаа ЗЦТ-тай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хяналт шалгалтын удирдамж боловсруулан батлуулж сар, улирал тутам хяналт шалгалт хийж хэвшсэн байна. Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2016 онд нийт 117 удаа хяналт шалгалтын ажил зохион байгуулж 27711 тээврийн хэрэгслийг хамруулан шалгахад 3262 тээврийн хэрэгслийн жолооч Жолоочийн даатгалын тухай хууль зөрчсөн байсныг илрүүлж арга хэмжээ авчээ. Орон нутгийн салбарын ажилтан, менежерүүд жолоочийн даатгалын тухай хуулийг зөрчсөн

эдгээр жолоочийн зөрчлийг газар дээр нь арилгуулснаар замын хөдөлгөөнд оролцуулсан байна.

2014, 2015, 2016 онуудын салбарын үйл ажиллагааны тоон үзүүлэлтүүдийг харьцуулбал:

Хүснэгт 18

№	Үйл ажиллагаа	2014	2015	2016
1	Шалгалтад хамрагдсан тээврийн хэрэгслийн тоо	16675	56009	26300
2	Илрүүлсэн зөрчлийн тоо	3796	13898	2758
3	ЖДТХуулийн 28.1.1-н дагуу хариуцлага хүлээлгэсэн жолоочийн тоо	1452	122	2*
4	Даатгалын тохиолдлын дуудлагын тоо	828	461	643

*2016 оны 4 дүгээр сараас ЖДТХуулийн 28.1.1-н дагуу хариуцлага хүлээлгэхгүй болсон.

2015 онд ЗЦТ-тай хамтран зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хийсэн хяналт шалгалтын хүрээнд илрүүлсэн зөрчлийн тоо /13898/ хамрагдсан тээврийн хэрэгслийн тоотой /56009/ харьцуулахад 24,8 хувь байсан бол 2016 онд 10,4 хувьтай болсон нь Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт сайжирсаныг харуулж байна.

Хууль зөрчсөн жолоочийн ихэнх нь даатгалын гэрээнд нэр бичигдээгүй тээврийн хэрэгслийг жолоодон замын хөдөлгөөнд оролцох, тээврийн хэрэгслийн өмчлөлийн нэр солигдох үед даатгалын гэрээ хүчингүй болно гэдгийг ойлгоогүй зэрэг зөрчлүүд давтагдан гарсаар байна.

Мөн зам тээврийн ослыг бууруулахад чиглэсэн ажлын хүрээнд орон нутгийн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах, төрийн болон төрийн бус байгууллагуудад сургалт хийж жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах талаар салбарууд харилцан адилгүй ажилласан байна. Тайлант хугацаанд, салбарууд нийт 183 удаагийн сургалт хийж 7368 иргэдийг хамруулж жолоочийн даатгалын ач холбогдлыг сурталчилсан сургалт хийж, иргэдийн асуултанд хариулах, даатгалын гэрээг хийхдээ юуг анхаарах талаар зөвлөлгөө өгч Баян-Өлгий аймагт MNB-2 телевизээр, Увс аймагт МВС Увс телевизээр, Сүхбаатар аймагт ВВН телевизээр тус тус сурталчилсан байна. Ялангуяа Баян-Өлгий, Булган, Говь-алтай, Дорноговь, Орхон, Сүхбаатар, Хөвсгөл аймгууд илүү олон хүн хамруулж жигд сайн ажиллаж байна.

Мөн салбарууд төрийн болон төрийн бус байгууллага, хамтран ажилладаг байгууллага, иргэдтэй 5 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж 450 хүн, 58 удаагийн уулзалтаар 2064 иргэдийг хамруулжээ.

Салбарууд нь даатгагч нартай байгуулсан гэрээний дагуу 610 удаа, даатгалын сангийн 33 даатгалын тохиолдлын дуудлагад шуурхай албаны үйлчилгээг үзүүлсэн байна.

Холбооны үйл ажиллагаа болон Жолоочийн даатгалын тухай хуулийн ач холбогдлыг хулдаасан самбар, тарааж өгөх материал, цахим сүлжээ, орон нутгийн ТВ, ФМ, Лед дэлгэцээр дамжуулан сурталчилж хэвшсэн байна. Бүх салбар нь өөрийн фэйсбүүк хаяг нээж Жолоочийн даатгалын тухай хуулийн ач холбогдлыг цахим сүлжээгээр сурталчилж ажилласан үр дүнгээ өгч байна.

3.3 Дотоод хяналт, салбар, нэгжийн ажил дүгнэсэн тухай

Албан журмын даатгагчдын холбооны үйл ажиллагаа нь Даатгалын тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Албан журмын даатгагчдын холбооны дүрэм болон бусад холбогдох хууль эрхзүйн актад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, шалтгаан нөхцлийг тодруулан уг зөрчлийг дахин гаргуулахгүй байх, Холбоо хуулиар хүлээсэн үүргийнхээ хэрэгжилтийг хангуулахад холбогдох арга хэмжээ авах зорилго тавьж ажиллалаа.

Холбооны хэвийн үйл ажиллагааг ханган Удирдах зөвлөлийн тогтоолуудыг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ Гүйцэтгэх захирлын тушаалаар хууль, дүрэм, журамд нийцүүлэн эрх хэмжээнийхээ хүрээнд “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг нийт ажилтнуудаараа хэлэлцэн баталлаа.

2016 оны 9 дүгээр сард АЖДХолбооны ажилтнуудын мэдлэг, ур чадварын түвшин тогтоох шалгалтыг зохион байгуулж нийт ажилтнуудын 71,4% хамрагдсанаас дунджаар 65,5% хувь нь хангалтгүй гэсэн үнэлгээтэй дүгнэгдсэн явдалд дүгнэлт хийж зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн болно.

Орон нутаг дах салбарууд нь чиг үүргийнхээ хүрээнд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж байгаа боловч зарим салбарын менежерийн хариуцлагагүйгээс ажлыг нь дүгнэх боломжгүй, нэгдсэн дүн, тайлан үнэн зөв гарахгүйд хүрээд байсан явдлыг анхаарч үзэн орон нутаг дахь салбаруудыг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй ахлах ажилтны орон тоог бий болгон ажиллуулж байна.

2016 оны 11 дүгээр сард АЖДХолбооны 5 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулж Санхүүгийн зохицуулах хорооноос тус Холбооны ажлыг дүгнэн “Талархал”-ын бичиг ирүүлсэн бөгөөд ажил мэргэжлийн хувьд бусдыгаа тэргүүлэн ажиллаж буй мэдээлийн сангийн дарга Т.Шинэцэрэг, мэдээллийн сангийн ажилтан Г.Ганбаяр, архив, бичиг хэргийн ажилтан Б.Энхсаруул нар Залуучуудын холбооны шагналаар, мэдээллийн сангийн дарга Т.Шинэцэрэг, сургалт сурталчилгаа хариуцсан ахлах ажилтан Д.Тунгалаг нар Даатгагчдын холбооны шагналаар тус тус шагнууллаа. Жолоочийн хариуцлагын даатгалыг хэрэгжүүлэхэд даатгагч, зуучлагч, төлөөлөгч 3000 гаруй хүн оролцож байгаа бөгөөд энэ хүмүүсийн дотор сайн ажиллаж байгаа байгууллага, хүмүүсийг АЖДХолбооноос шагнаж урамшуулах хүсэлтүүд ирсэнтэй холбогдуулан Холбооны нэрэмжит шагнал бий болгох нь зүйтэй гэж үзэж журам батлагдаж шийдвэр гаргалаа. АЖДХолбооны шагналаар даатгагчдын тодорхойлолтыг үндэслэн 2016 онд 10 хүн шагнасан байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Дүгнэлт:

Жолоочийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг өнгөрсөн таван жилийн үйл ажиллагаанд тулгуурлан дүгнэлт өгч, цаашид улам боловсронгуй болгох боломж бүрдсэн гэж үзэж байна.

Албан журмын даатгагчдын холбоо Даатгалын тухай, Жолоочийн даатгалын тухай хуулиар хүлээлгэсэн үндсэн үүргийг хэрэгжүүлснээр даатгагчдын үйл ажиллагааны уялдаа холбоог хангагдаж даатгагч, даатгуулагч, хохирогчийг мэдээллээр хангах, мэдээлэл солилцох, даатгуулагч, хохирогчид учирсан санхүүгийн эрсдлийг арилгах, улмаар иргэдийн амьжиргааг хэвийн үргэлжлүүлэх төрийн бодлого хэрэгжих нэг нөхцлийг хангаж байна.

Албан журмын даатгагчдын холбооноос Даатгалын сан, Мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж гишүүддээ үйлчлэх болон даатгалгүй этгээдийн бусдад учруулсан хохирлыг төрийн нэрийн өмнөөс арилгах нөхөн төлбөрийг олгох үйлчилгээ үзүүлж даатгалын тухай сургалт, сурталчилгаа хийсний үр дүнд жолоочийн хариуцлагын даатгал даатгалын салбарын хөгжилд бодитой түлхэц үзүүлж чадсаныг зориуд тэмдэглэх нь зүйтэй.

Даатгагчдаас 2015 онд, 14,479,9 сая төгрөгийн нөхөн төлбөр олгогдож байсан бол 2016 онд 13,456,2 сая төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцогчдын хариуцлага дээшилж байгааг ослын тоо буурч нөхөн төлбөр олгох хэмжээ буурсан дүнгээс харагдаж байна. Мөн, цаашдаа Албан журмын даатгагчдын холбооны Даатгалын сан бүрдүүлэх эх үүсвэрийг төрөөс болон даатгагчдаас төвлөрүүлэхийг зогсоож хамтран ажиллах гэрээгээр зохицуулах нь зах зээлийн зарчимд нийцнэ гэж дүгнэж болохоор байна. Мэдээллийн санг бүрдүүлэх, ажлыг ирээдүйг харж зарчмын өөрчлөлт хийх шаардлага байна гэж дүгнэж байна.

Албан журмын даатгагчдын холбооноос болон орон нутгийн салбар бүр жолоочийн хариуцлагын даатгалын ач холбогдлыг мэдээллийн олон сувгаар сурталчилсаны үр дүнд иргэдэд мэдээлэл жигд хүрч, даатгалын ач холбогдлыг ойлгох, бодит үр шимийг нь хүртэх боломж эрс дээшилж байна. Жолоочийн хариуцлагын даатгалын бодит хэрэгжилт үр дүн нь хариуцлагын даатгал Монгол улсад хөгжих бодит суурийг бий болгож чадлаа. Харин даатгалын тохиолдлыг шалгаж хохирлыг үнэн зөв шуурхай тодорхойлох шуурхай албаны үйл ажиллагаа хуулийн зорилгыг хангаж зохион байгуулагдаж байгаа боловч нэгдсэн удирдлага зохион байгуулалтад орж чадахгүй таван жил болох гэж байгаа явдалд тал талдаа анхаарах шаардлагатай.

Хариуцлагын даатгалыг хөгжүүлэхэд даатгалын мэргэжлийн оролцогчдын ёс зүй, ажлын арга барилд эрс өөрчлөлт хийх цаг болжээ. Хариуцлагын даатгалыг ашиг олох бүтээгдэхүүн гэж хандахаас илүүтэй нийгмийн өмнө, бусдын өмнө хариуцлага хүлээж хууль дээдэлж, амьдрах арга ухаан, мэдлэг соёл өөртөө бий болгож хэвшүүлэх эдийн засгийн механизм, хөшүүрэг гэдгийг ойлгож ашиглах нь юу юунаас чухал гэдэг нь харагдаж байна.

2016 оны 08 дугаар сараас хойш хийж гүйцэтгэсэн ажлуудыг товчоолвол:

1. Бүтэц орон тоог хуульд нийцүүлэн шинэчилж ажлын ачааллыг тэнцвэржүүллээ. /Удирдах зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 21 дүгээр тогтоол/ АЖДХолбоо нь цомхон орон тоотой, засаглалын зөв тогтолцоо бүхий алба байхыг зорьж байна.
2. Нэгжүүдийн үйл ажиллагааны нэгдмэл байдал, уялдаа холбоог сайжруулж орон нутаг дахь салбаруудын хариуцлагыг өндөржүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах зорилгоор Булган-Орхон, Сэлэнгэ-Дархан уул аймгуудын салбарыг нэгтгэн Холбооны орон нутгийн

салбаруудыг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй ахлах ажилтан ажиллуулж байна.

3. Мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах, программыг лицензжүүлэх ажлыг гүйцэтгэхээр 2017 оны төсөвт суулган тендерийн сонгон шалгаруулалт хийх гэрээ байгуулах ажил эхлээд байна. Мэдээллийн санг улам бүр хөгжүүлж даатгагч, зуучлагч нарын үйлчилгээ авах төв байхаар зохион байгуулахад гол ажил чиглэгдэж байна.
4. Гүйцэтгэх захирлын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 02/138 тоот тушаалаар хамт олноороо хэлэлцэн “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг хууль зөрчиж оруулсан өөрчлөлтүүдийг хасч дахин боловсруулж шинэчлэн баталлаа.
5. Улсын хэмжээний шуурхай албаны үйл ажиллагааг жигдрүүлэх, тайлан мэдээг мэдээллийн санд төвлөрүүлэх, хяналтын төвлөрсөн тогтолцоонд шилжүүлэх зорилгоор Удирдах зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор **“Шуурхай албаны ажилтнуудад тавигдах шалгуур, шаардлага”, “Жолоочийн даатгалын шуурхай албаны ажилтны сургалтын хөтөлбөр”**-ийг батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Жолоочийн даатгалын тухай хууль бодитой хэрэгжиж байгаа ч даатгуулагчдад туслалцаа үзүүлэх шуурхай албаны нэгдсэн удирдлага үгүйлэгдэж, мэдээллийн нэгдсэн байдал хангагдаж чадахгүй байга явдалд дүгнэлт хийж шаардагдах арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.
6. Орон нутгийн салбаруудтай цахимаар холбогдож сургалт, зөвлөгөө, зааварчилгаа өгөх ажлыг эхлүүлж томилолтын зардлыг хэмнэх боломж бүрдүүллээ.
7. Орон нутаг дахь салбаруудын өмнө тавьсан зорилт үндсэндээ хангагдсан гэж үзэж байна. Үүнд:
 - Даатгалын компаниудыг бэхжих хүртэл шуурхай албаны дуудлага авч үйлчлэх
 - Жолоочийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг тогтмолжуулах, жолоочийн даатгалд хамрагдаж хэвшүүлэх
 - Сумдын хэмжээн дэх тээврийн хэрэгслийн тооллого хийж техникийн үзлэг оношлогооны үеэр даатгалын ажлыг зохион байгуулж хэвшүүлэх, мөн замын цагдаагийн газар, тээврийн үндэсний төвтэй хамтран хяналт шалгалт явуулж хэвшүүлэх
 - Иргэдийн даатгалын мэдлэгийг сайжруулах сургалт, сурталчилгааны ажил явуулж хэвшүүлсэн гэх мэт.
8. Холбооны үйл ажиллагааны зарим үрэлгэн байдлыг хасч даатгалын сангийн хөрөнгийн зардлыг хэмнэхтэй холбоотой арга хэмжээнүүд авлаа. Цаашид анхаарч шийдвэрлэх ажил чнэлээд байна.
9. Холбооны удирдах зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 34 дүгээр тогтоолоор **“АЖДХолбооны нэрэмжит шагнал бий болгох, шагнал олгох журам”**ыг батлуулсан нь Холбооны нэр хүндийг өргөсөн үр дүнтэй ажил боллоо.

АЛБАН ЖУРМЫН ДААТГАГЧДЫН ХОЛБОО 2016 ОН